

Аквариум

Би энд яг нэг жил болж байна. Хүүхэн болгон атаархаж, хүн болгоны магтдаг байсан зөөлөн, булбарай арьс минь одоо хэдийнээ улаан ягаан толботой, хатуу хайрсан бүрхүүл болон хувирчээ. Жил, яг нэг жш... Хүмүүс намайг загас гэж бодох болсоор яг жил болж байна. Хүмүүс ч гэж дээ, үнэндээ бол төрсөн хүүхдүүд маань надаар зугаацах болсоор гурван зуун жаран таван хоног өнгөрөөд байгаа хэрэг. Энэ аквариумыг худалдан авч байхдаа би өөрийнхөө авсыг бэлдэж байна гэдгээ мэдээгүй юм. Мэдээж, үүнийгээ хэрэв мэдсэн бол арай томхоныг сонгох байлаа. Би угийн бачимдуу хүн. Энэ жижигхэн аквариум байтугай дөрвөн өрөө сууц маань, хүн болгон саруулхан, томыг нь бахдан хэлэлцдэг албан тасалгаа маань, цаашлаад дуу шүлэг бүхэнд хязгааргүй хэмээн магтагддаг Монголын өргөн тал, дуусахгүй мэт үргэлжилдэг цэлийсэн уудам нутаг маань надад багадаад байгаа юм шиг санагдан үргэлж, давчдаж явдаг байлаа. Надад бусдаас илүү, илүү хамаагүй илүү орон зай хэрэгтэй байсан юм. -Хүсээд байсан орон зай маань харин энэ бяцхан аквариум байж гэдгийг зөгнөж мэдэх нь байтугай зүүдлээ ч үгүй явтал бурхан миний өмнөөс бүгдийг шийдчихдэг байна шүү. Аквариум. Миний тэр орон зай, хүсэл гэдэг маань ийм л хэмжээний юм байж шүү дээ. Охин маань аквариумаа гоёх гэж, миний хэдэн жил хичээн байж цуглуулсан гоёмсог дун хясаануудыг өөрийн минь дээрээс нэг нэгээр нь цүлхийтэл хийж эхлэхэд би анх сэрж, ухаан орсон юм. Урд нь бол миний алганд элбэгхэнээ багтдаг байсан далайн бяцхан яснууд одоо надаас хэдэн арван хувь том болжээ. Би сандарч, нуулгүй хэлэхэд үхтлээ айж, ийш тийшээ үсчиж эхлэв. Үсчих тусам миний жаахан охин өхөөрдөм хөөрхнөөр инээд алдан хясаануудаа дээрээс минь шиднэ. Ээжийнх нь айдас бүр хайртай охиныг нь баярлуулна. Бурхан минь! Та юу хийчихэв ээ? Үгүй ээ, үгүй, үнэндээ бол энэ түүний хийсэн ажил биш. Бурхан үүнд ер хамаагүй. Угаасаа бурхан юунд л хамаатай байдаг билээ Ээ. Энэ бүгд ердөө л Замзагийн хийсэн ажил. Би Кафкагаас ч илүү Замзад хайртай байдаг юм л даа. Хүүхэд байхдаа бол Квазмидод хайртай байсан. Магадгүй Квазимодо намайг Замза руу ийм хүчтэй түлхсэн ч юм билүү. Аль эсвэл тэр Замза гэдэг нь... Мэдэхгүй ээ, мэдэхгүй. Юутай ч би унтахдаа Замзагийн нэрийг шивнэж байснаа л санаж байна. Сэрээд хартал энэ. Энэ бүхэн. Харин тэр намайг эмэгтэй юм болохоор, тэгээд бас нэлээдгүй сэжигч юм болохоор, жаран хөлт биш ачтлаг хайрстай, бяцхан бүлтгэр загас болгочихож. Хорхой шавьжаас учиргүй айдгийг минь ч бас бодолцоо биз. Замзагаас ялгаатай өөр нэг юм бас бий. Манай гэрийнхэн намайг загас болсныг мэдэхгүй байгаа юм. Нэр минь сураггүй алга бологсдын дунд бичээтэй, цагдаагийнхан маш хүчтэй эрэл хайгуул хийсэн, хөөрхий нөхөр маань хамаг хөрөнгөө тэр эрэлд зарцуулсан, шөнө болгон тэр ганцаархнаа шил архи уудаг, уух болгондоо миний нэрийг шивнэн, шивнэн уйлдгийг би мэднэ. Бүр уйлдаг юм шүү. Энэ нь намайг бага ч атугай тайвшруулж байлаа. Ах дүү нарын тухайд ч гомдолтгүй. Тэд урьд нь жилдээ нэг л удаа, тодруулбал, цагаан сараар л нэг үзэгддэг байсан бол одоо бараг өдөр бүхэн ирцгээдэг, бүр цагийн хуваарь гаргачихсан, ээлж ээлжээр ирж, хоёр хүүхдийг маань эргэж тойрч, асарч сувилдаг болсон. Тэр ч байтугай хоёр ах нэг удаа аквариумын дэргэд зогсоод, нөхрөөс маань тусдаа хувийн мөрдөгч хөлслөн авцгааж, хөөрхий түүнийг минь мөрдөж мөшгих төлөвлөгөөтэй байгаагаа шивнэлдээтэхэв. Том ахын бодлоор бол, нөхөр маань намайг алчихсан байж магадгүй гэнэ. Тэд өөрсдийн орон сууцыг барьцаанд тавиад, мөрдөгч хөлслөхөөр шийдэцгээв. Үүнийг сонсоод миний нулимс цийлэгнээд л ирэв. Загасанд нулимс байдаггүй гэлцдэг нь огтоос худал шүү. Надад хайртай хүн өчнөөн олон бий, тэд миний төлөө юу ч хийхэд бэлэн гээд бодоход нулимс ч багадмаар юм билээ. Үүнчлэн надад тайвшрах юм зөндөө. Гэсэн ч сэтгэл зовоох юм түүнээс олон байсан нь мэдээж. "Загас авч өг" гэж байнга шалдаг байснаараа охин л намайг асарч тойлно. Тэр зургаахан настай болохоор усныхаа халуун хүйтнийг ч тааруулж иэдэхгүй. Бас нэг удаа хоолны оронд үзэгний хар бэх хийгээд арай л ээжийгээ алчихаагүй. Заримдаа ч хоол өгөхгүй хоёр гурав хононо гээч. Уг нь бол би өлсдөггүй л дээ. Замза намайг загас болгохдоо өөр шиг нь өлсөөд үхчихгүй байх талаар бодолцсон бололтой, огт хоол хүнсний хэрэг

гардаггүй байсан юм. Зүгээр л, хүн байхдаа хоёр хоног хоолгүй явж чаддаггүй байсан тухай бодол маань л охины хаяж өгсөн тэжээл рүү ухасхийлгэдэг байлаа. Тиймээ, би загас болсон нь миний хувьд төдийгүй манай гэрийнхний хувьд жинхэнэ хувирал боллоо. Нөхөр маань хорин жил үхэн хатан зүтгэж байж хүрсэн өндөрлөгөөсөө буув. Өөрөөр хэлбэл тэр намайг үргэлж бухимдуулдаг байсан өнөөх завгүй, даргын ажлаа бүрмөсөн орхив. Энэ үнэхээр, үнэхээр таатай, хамгийн таатай мэдээ байсныг нуугаад яахав. Тэр маань охиноо тэврэн сууж байгаад яг аквариумын дэргэд энэ тухай яриу. “Аав нь одоо охинтойгоо үргэлж хамт байна. Ахиж ажилдаа явахгүй “ гэж хэлэхэд нь би арай л уснаасаа үсрээд гарчихсангүй. Хүү маань хэдийнээ үймүүлэхээ больжээ. Тэр хэзээ ч миний үгэнд орж байгаагүй юм. Хэтэрхий дураараа, 12 настай хүүхдэд баймааргүй хэвлүүн яриатай хүүтэйгээ би огт таардаггүй байсан юм л даа. “Хичээлээсээ өнөөдөр оройтолгүй ирээрэй “ гэхэд оройтно, “За яахав, өнөөдөр хичээлээ тараад гадаа тогловол тогло л доо” гэхээр ороод ирнэ. Түүний зөрүүд зан намайг галзууруулах дөхдөг сөн. Гэтэл одоо тэр Тэр биш болжээ. Нэг л биш. Хичээлээсээ орж ирүүт шавхайтай гутлаа тайлаад зогсохгүй, бүр тосолж тавиад гэрийн шаахайгаа өмсдөг болсныг нь охин маань аквариум руу хэдэн чийгийн улаан хорхой цацах үеэрээ нөгөө л өөртэйгээ ярих дуртай балчирхан зангаараа шивнэн ярихад нь би бүр айж орхив. Түүгээр ч зогсохгүй хүү маань гараа угааж байж цай цуугаа уух ч юм уу, даалгавраа хурдхан шиг хийчихээд нохойгоо салхилуулахаар аваад гардаг болсон гэнэ. Тэр яг миний өөртэй нь зууралддаг байсан шигээр нохойдоо халамж тавих болжээ. Дүүтэйгээ хэрүүл цуугиан үүсгэж, бөөн уйлаан майлаан болдог нь бүр таг. Тэр ч байтугай нэг удаа аавдаа өрөвдмөөр аяархан дуугаар “Би дүүгийнхээ үсийг самнаад өгье л дөө” гэх нь сонсогдсон шүү.

Охин бол бүр ч өөрчлөгдсөн. Тэр өдөржин загастайгаа (хөөрхий, ээжтэйгээ л гэсэн үг) ярьж өнжинө. Урьд нь бол өдөржин чихэр жимс нэхэж, хормой хотноос зууран уйлж, унжин эрхэлдэг байлаа. Ямар ч амттан шимттэн, ямар ч гоё тоглоом түүний амнаас унадаг сан. Түүнд арван ширхэг чихэр ч өгсөн, арван уут чихэр ч өгсөн адилхан. Тэрхэн дор нь цааш харуулчихна. Харин одоо бол айл амьтан ах дүүсийн өрөвдсөндөө өгсөн хэдэн чихрийг огт идэхгүй, юунд ч юм хурааж цуглуулах болжээ. Энэ бүх хувирал, дандаа сайнаар эргэсэн хувирал надад даанч таалагдаж байлаа. Аквариум маань эхэндээ нэг л давчуу, харанхуй, зэврүүн санагдаж байснаа сүүлдээ дасаад ирэв бололтой, давчуу биш, харанхуй биш, зэврүүн биш болоод ирэв. Гурван сар өнгөрөхөд би “хүн байхдаа яах гэж ийм жаахан аквариум худалдан авав аа” гэж харамсаж байснаа ор тас мартсан төдийгүй, энэ бяцхан шилэн хорго ч бас өчнөөн орон зайтай болохыг гүнзгий мэдрэв. Шилэн хоргоныхоо өнцөг булан бүрийг андахгүй сайн мэддэг болсон нь өөрт нэг л тааламжтай. Хаашаа л харна хоргоны гаднах бүх юм тодорхой. Хүүхдийн өрөөний голд байх хичээлийн ширээн дээр тавьсан болохоор би хоргон дотроосоо хаашаа л бол хаашаа хараад охиноо эсвэл хүүгээ олоод үзчихнэ. Нөхөр маань өдөржин шахуу хүүхдийнхээ хичээлийг давтуулж, өөрийн гараар охиныхоо үсийг самнаж, хүүгийнхээ зургийн хичээлийг хийх гэж будаг цаас болон суухыг хараад би бүр уярч орхино. Орой нь тэр бидний хайрын түүхээр үлгэр зохион ярьж хүүхдүүдээ унтуулах нь нэг л дотно. Тэр маань намайг санаж гүйцээд байгааг би дуугаар нь, санаа алдах өнгөөр нь мэдэж байлаа. Гэвч хамгийн сонирхолтой нь тэр гурав маань хоорондоо миний тухай огт үл ярих бөгөөд охин хүртэл, ганцаархнаа байхдаа ч ЭЭЖ гэж ганц дуугардаггүй байлаа. Энэ нь надад нэг л таатай санагдахгүй байв. Гэвч аая гэхээ дээ, юм болгон миний хяналтаас хэдийнээ гарчихсан. Нэг удаа би шилэн хоргоныхоо хамгийн дээд хэсэгт очиж байгаад, уснаас хэр чадлаараа толгойгоо цухуйлгаж байгаад, охиныхоо өөдөөс бүлтийтэл ширтэв. Намайг таньж магадгүй гэж горьдсондоо л тэр. Гэтэл тун санаадгүй юм болов. Охин өөдөөс минь учиргүй ширтэж байснаа Алтан загас аа, чи миний гурван хүслийг биелүүлээд өгөөч! Гэж үнэн сэтгэлээсээ гуйх нь тэр. Тэгээд ийм гурван хүсэл шивнэлээ. Нэгдүгээрт манай ээжийг авсан ах буцааж өгөөч! Хоёрдугаарт ээжид миний цуглуулгыг аваачаад өгөөч! Гуравдугаарт, би ээжийнхээ өвөрт унтмаар байна!

Миний зүрх эмтрэх шиг болов. Тийм ээ, загас ч бас зүрхтэй байдаг юм шүү. Тэр нэг ч удаа миний тухай ааваасаа асуугаагүй, бас намайг санаж уйлаагүй болохоор би санаа зовохгүй байсан юм. Гэтэл... Хөөрхий нялх үр минь... Тэр намайг яагаад өөр ахтай хамт яваад өгсөн гэж бодсны учрыг харин би бодоод, бодоод олсонгүй. Харин цуглуулга гэдэг нь өнөөх чихрүүд ээ. Би охиноо хэмжээлшгүй ихээр өрөвдөж байлаа. Гэвч загас бол загас шүү дээ. Тэр ярьж чадахгүй. Ярьлаа гэхэд, та бод доо, хэн нэгнийг өрөвдөж байгаагаа хэллээ, ярьлаа, илэрхийллээ. Тэгээд? Тэгээд л болоо. Үнэндээ тэгээд л болдог шүү (Зээ. Ихэнх хүн өөрийнхөө зовлонгоос илүү гарч чаддаггүй. Тийм болохоор хэлэх хэлэхгүйн хооронд ямар ялгаа байна аа?

Аквариумын загас юм боддог уу? Гээд та өөрөөсөө асуу л даа. Инээд чинь хүрнэ. Бас тэр бяцхан амьтад гунигладаг. Ганцаарддаг, уйддаг гэвэл таны бүр хөхөөс хөх инээд хүрнэ биз дээ. Би үнэхээр гуниглаж, ганцаардаж, уйдаж байв. Гэвч үүнийг маань хэн ч мэдэхгүй байгаа нь л хамгаас, хамгаас, хамгаас харамсалтай, хамгийн тарчлаантай байлаа. Өдөр хоног өнгөрсөөр нэг л мэдэхэд би гунигтаа, хүмүүн бусын ганцаардалдаа, басхүү ер бусын уйдалтандаа дасаж орхив. Ерөөсөө дасна гэдэг гагц хүний ч биш бүхий л амьтны зан бололтой. Би өөрийгөө, хүү охиноо, нөхрөө өрөвдөхөө болив. Тэртээ тэргүй тэд маань надгүйгээр амьдарч сураад байгаа нь, энэ хачин янзын хагацалдаа дасч эхлээд буй нь ч харагдаж байсан юм чинь.

Найман сарын дараа, загас болсноос хойш шүү дээ, нэгэн шөнө, нөхөр маань миний үй зайгүй найз эмэгтэйг дагуулж ирэв. Хүүхдүүд дунд ахынд очицгоохоор явсан байлаа. Найз эмэгтэй маань миний бяцхан охины орон дээр сууж байгаад ...Ингээд л тэд секс хийцгээсэн юм даа. Нөхөр маань надтай хийдгээсээ нэг л өөр, хачин шуналтай, түрэмгий янзаар эр эмийн ажил хийхийг хараад би бүр гайхаж орхив. Гэвч, хамгийн сонирхолтой нь надад хардах, харамлах сэтгэл ер төрсөнгүй. Нээрэн шүү, загас хүнээс ялгаатай нь бусдаас юугаа ч харамладаггүй. Хүмүүс л харамч, өмчирхөг байдаг юм билээ. Дараа нь тэд баахан худлаа ярьцгаав. Найз эмэгтэй маань “Нөхөртөө хайргүй” гэж уйлагнан хэлэхэд, нөхөр маань хариуд нь “Би мэднэ ээ. Угаасаа л мэддэг байсан” гэх нь тэр. Намайг загас биш хүн байхад тэр миний найзуудаас чухам түүнийг л үзэж чаддаггүй байсан юм л даа. Найз эмэгтэйн яриагаар бол манай нөхөр түүний хоёр дахь хүн гэнэ. “Битгий худлаа яриад байгаач ээ, энэ бол чиний унтсан арван тав дахь эр шүү дээ” гэж би тэсгэлгүй хашгирав. Хардсандаа биш шүү, зүгээр л худал хэлсэнтэй нь эвлэрэхийг хүсээгүйдээ тэр. Гэвч тэд сонссонгүй. Ерөөсөө хүн шиг дүлий амьтад хорвоо дээр үгүй дэг ээ. Найзын маань яриагаар бол би нууц амрагтай байсан гэнэ. “Бодвол түүнтэйгээ одоо хамт байгаа биз дээ” гэж ертөнц дээрх цорын ганц найз маань гуниглангуй царайгаар шивнэтэл, ертөнц дээрх цор ганцхан хань минь үүнийг сонсуут ухасхийн босч, дахиж секс хийхийг хүсч байгаагаа нэг л хачин дуугаар илэрхийлээтхэв. Миний найз ч хариуд нь дуртайяа зөвшөөрч мөн л надад танил бишээр инээд алдав. Би тэдний хэрхэн дуу алдацгаахыг, бүр сүүлдээ бие биенийхээ нурууг маажихыг алдалгүй харсаар шөнийг өнгөрүүлэв. Нөхөр маань бүрэн өөрчлөгджээ. Үгүй ээ, ерөөсөө тэр өөр хүн байсан юм байна. Энэ тухай бодон санаа алдсанд үүр цайлаа.

Нэг өглөө хүү маань хичээлээ хийж дуусаад өдрийн тэмдэглэлээ авч шүлэг бичив. Тэр модны тухай шүлэг бичжээ.

Бичиж дуусаад тэр амандаа аяархан шивнэн уншсанаа, гэнэт нөгөө дэвтрээ юу ч үгүй жижиглэн урж, өрөөгөөрөө нэг цацчихаад гарч гүйв. Охин тэр цааснуудыг нь цас болгон өөрийнхөө дээрээс цацаж, өдөржин тоглолоо.

Хүү яагаад үе, үе хачин ууртай болчихдог байсныг, бас яагаад өрөөгөөр нэг урсан дэвтэр хөглөрч байдаг байсныг би тэгэхэд л ойлгов. Бурхан минь, гэтэл би түүнийг математикч болгохоор өмнөөс нь шийдчихсэн байсан сан. Яасан дураараа байж вэ, би хүн байхдаа “Хн, хэнийгээ дуурайгаад ийм яруу найрагч болчихдог байна аа? “ гэж би өглөөнөөс оройг хүртэл сэлэн байхдаа ихэд бодлогшров.

Оройхон хэрд хүү маань гаднаас жигтэйхэн ядарчихсан царайтай орж ирээд ийш тийш харан хэсэг сууж байснаа гэнэт босч аквариум руу дөхөн ирлээ. Дэггүйтмээр санагдаж л

дээ. Тэгээд усан будгуудаа савнаас нь ховхлон аваад, нэг нэгээр нь ус руу цүлхийтэл хийж эхэллээ. За ингээд би улаан, ногоон, шар өнгийн тэр аймшигт хорнуудаас зугтан ийш тийш үсчиж гарав аа. Авралт бяцхан охин минь орж иртэл миний хүү надаар зугаацсан юм даа. Гэнэт л ... Тийм ээ, бүх юм гэнэт л болдог шүү дээ. Би учиргүй ядарснаа гэнэт мэдэв. Бүтэн жил өнгөрчээ. Загас юу ч хийдэггүй нь үнэн боловч би үнэхээр ядарч. Үзэх ёсгүй байсан бүхнээ харсаар байгаад бүр туйлдаж орхижээ. Загасны нүдээр би ойр дотныхоо хүмүүсийн нууц руу өнгийх болгондоо өөрөөсөө ч юм уу, хэн нэгнээс, заримдаа тэднийхээ өмнөөс түгшиж, ичиж, айж, шаналдаг байсан юм. “ Хүн болгон л хоёр дүртэй аж. Үнэндээ тэр хоёр дүрийнхээ нэгийг нь л бусдад харуулахад хангалттай. Хэн ч өөрийнхөө сайн, сайхан гэж бодсондоо буй болгосон тэр дүрээ л бусдад харуулахыг хүсдэг, түүгээрээ л баг хийж явдаг. Хоёр дахь нь хэдий өөр байлаа ч бусдад харуулахыг хүсч байгаа тэр багаар нь л хүнд хандах хэрэгтэй юм байна. Заавал багийг нь хуулах гээд, нөгөө жинхэнэ дүрийг нь үзэх гээд байх хэрэг юу байна аа?” Би эцсийн энэ мэтчилэнгийн гүн ухааны гаргалгаанд хүрээд жирийн ч нэг загас биш, бясалгагч загас болж орхисондоо олзуурхаж л байлаа. Уг нь надад загас байх таалагдаж байсан юм шүү. Ямар ч хариуцлага хүлээхгүй, хэний ч төлөө амьдрахгүй, хэнийг ч хайрлахгүй, бас харамлахгүй, хэнд ч уурлахгүй, уцаарлахгүй, загнахгүй, загнуулахгүй. Уг нь хүн ингэж амьдарч болно шүү дээ. Яах вэ гэж би ингэж өөрийгөө ч, өрөөл бусдыг ч зовоож явсан юм бол оо, хөөрхий. Гэвч... Аквариум доторх өдөр хоногууд улам л удаан, улам л энгийн болсоор байв. Эхэндээ юм бүхэн нээлт шиг санагддаг сан. Одоо бол үгүй. Байдаг л нэг түүх, байдаг л нэг амьдралыг харсаар бүүр дасчээ. Хүн, /биш ээ загас, за яалаа гэж дээ, хүн. Хүн байлгүй яах вэ. Хүн. Би загасны тухай ярьж байгаа шүү дээ. За, үнэндээ ялгаагүй юм./ Хүн ямар нэг юманд дасаад ирэхээрээ л ядардаг. Гэтэл бид бодохдоо өөрсдийгөө ямар нэгэн юманд дасахгүй байгаагаасаа л ядарч байна гэж эндүүрээд байдаг бололтой. Үнэндээ бол юманд хэт дасчихаараа л ядардаг юм билээ. Би шилэн хоргонд биш унтлагын өрөөнд, зөөлөн буйдан дээр хэвтэж байхдаа сэрсэн юм. Бүх юм хэвэндээ оров. Болсон бүх явдал зүүд байсан гэж би өөртөө итгүүлэхийг хүсдэг боллоо.

Нөхөр маань одоо ажлаа хийж байгаа. Хүү миний өөдөөс үг сөрдгөөрөө сөрөн, уурладгаараа уурлана. Охин чихэр жимсний хэрүүлээ хийж эхлэв. Найз эмэгтэй маань утсаар ярьдгаараа ярьж, нөхөртөө урьд урьдынхаасаа илүү хайртай болсноо шивнэн инээнэ. Нөхөр маань урьдын адил, тэр ч байтугай секс хийхдээ хүртэл яг урьдынх шигээ эелдэг зөөлөн хэвээр, үргэлж л миний хүсэлд бүхнийг захируулдаг нь бүр яг хэвээрээ шүү. Харин би хүүтэйгээ огт өөрөөр харьцдаг болсон. “Тоогоо бод “ гэж толгой руу нь тоншдоогоо болиод шүлгийн номууд авч өгөх болов. Амьдрал үргэлжилсээр. Гэвч бидний амьдрал урьдынхаасаа нэг л өөр, илүү амттай ч юм шиг, бас хүү илүү нууцлаг ч юм шиг байх болов. Ямар нэгэн юмаа алдаад эргүүлэн олж авсан хүн ахин түүнийгээ алдахыг хүсдэггүй шүү дээ. Тэр л ёсоор юм бүхэн сайн сайхны зүг эргэчихжээ гэж би боддог болоод байна.

Нэг удаа би нөхрөөсөө намайг эзгүй байхад болсон бүхнийг нууж хаалгүйгээр, нэгийг ч үлдээлгүйгээр ярихыг хүсэв. Бүхнийг мэдэж байсан мөртлөө шүү дээ. Ээ дээ, энэ хүмүүс үү? Загас бол заяа нь тэгэхгүй. Гэтэл юу сонссон гээч? Түүний ярьсныг сонсоод би үнэхээр цочирдсон шүү. Ах нар маань миний ханиас мөнгө нэхсэн гэнэ. Тэд түүнийг шоронд хийж, хүүхдүүдийг асрамжлагчаар өөрсдийгөө гэсэн баталгаа гаргуулж аваад, манай бүх хөрөнгийг өөрсдийнхөө нэр дээр болгоно гэж сүрдүүлсэн гэнэ. Тэд манай нөхрийн ажил дээр очин, өдөр бүр хэрүүл шуугиан үүсгэдэг болсноос аргагүйн эрхэнд ажлаа орхиход хүрсэн юм байж. Нөхөр маань сэтгэлээр унан, шөнө болгон шахуу ганцаараа архи уудаг байсан тухайгаа ярихдаа тэсгэлгүй уйлав. Охин харин болгон угаалгын өрөөнд орж сууж байгаад Ээж ээ гэж шивнэн, шивнэн уйлдаг байсан гэнэ. Хүү харин математикч болохоор бүрэн шийдсэн төдийгүй, энэ чиглэлээр сонгонд явж байжээ. Тэр ийнхүү миний мэддэг байсан бөгөөд мэдээгүй бүх юмыг ярьж өгөв. Харин ганцхан найз эмэгтэйтэй маань хавьтсан тухайгаа л дурссангүй. Би ч асуусангүй.

Тэртээ тэргүй хэлэхгүй гэдгийг нь мэдэж байгаа юм чинь. Би нөхрөө өрөвдөн, өөдгүй муу ах нартаа гомдон удаан уйлав. Миний аквариум жижиг ч гэсэн надад бүхнийг харуулаад байна л даа гэж би боддог байлаа. Дөрвөн тал нь шил болохоор ертөнцийн дөрвөн зүг, найман зовхисыг харж байгаа юм шиг л санагддаг сан. Гэвч! Аквариум бол аквариум. Тэр гадуураа бас аквариумтай. Нөгөө гурван өрөөнд маань өрнөж байгаа амьдрал надад харагдахгүй. Цаашлаад, дөрвөн өрөө сууцнаас маань гадна болж буй бүхнийг, бүр цаашлаад... За энэ тухай бүрч ярилтгүй. Ах нарынхаа үнэн мөнийг мэдсэндээ, бас тэдэнд өширхсөндөө уйлж, уйлж тайвшраад би нөхрөөсөө ингэж асуулаа: -Чамд надад яриагүй юм үлдсэн үү? Ингэж хэлэхдээ би мэдээж хариу хүлээгээгүй юм. Зүгээр л асуусан хэрэг шүү дээ. Гэтэл нөхөр минь юу гэж хариулсан гээч? –Би чиний хамгийн сайн найзтай унтсан! Энэ бүлэг ингээд дуусах гэж байна. Ерөөсөө энэ түүх ингээд дууслаа. Нөхрийнхөө хэлсэн тэр үгийг сонсоод л надад гэнэт хачин уйтгартай болчихсон юм. Юуг ч урьдчилан таах аргагүй ажээ. Би нөхрөө надад худлаа ярина гэж, үнэнээ хэлэхгүй гэж итгэж байсан юм сан. Гэтэл! Үнэнийг ярьчихдаг байна шүү. Тэгэхэд л би үнэнийг ер хүсээгүйгээ, ерөөсөө юуг ч хайгаагүйгээ, /магадгүй юуг ч олгоогүйгээ гэх нь илүү оновчтой болох биз/ гэнэт ойлгов. Миний нууцаар харсан бүхэн худлаа юм байж шүү дээ. Жинхэнэ амьдрал гэдэг маань ердөө л энэ байж. Магадгүй, би бусдын тухай биш өөрийнхөө тухай мэдэхийг бүхнийг өөрөөс минь асуухаар шийджээ. Тэр надаас “Аквариумаа санаж байна уу?” гэж асуусан. Би удаан бодлоо л доо. Тэгээд ахин загас болохоор шийдээд байна. “Аквариум жижиг байх тусмаа сайн” гэж би Замзад хэлсэн.